

## БҮДДИЙН ШАШИН БУРИАДАД<sup>1</sup>

Товч түүхэн тойм.

Буриадын бүддийн шашны түүхийг дараах үед хуваан авч үзэж болно. Үүнд:

1. Эхэн үе – ХҮП-ХҮШ зуун
2. Цэцэглэлт, дэвшлийн үе – XIX – XX зууны эхэн үе.
3. Хэлмэгдэл, уналтын үе – 1920-иод оноос 1945 он хүртэл.
4. Бүддийн шашны дахин сэргэлтийн үе – 1945 – XX зууны 80-аад оны сүүл.
5. Бүддийн шашны сэргэн мандалтын үе – XX зууны 80-аад оны сүүлээс эдүгээ хүртэл.

1. **Эхэн үе - ХҮП-ХҮШ зуун.** Буриадуудын дунд бүддийн шашин дэлгэрэх үйл явц нь дорнод монголын хэсэг ноёд өөрийн харьяат албатын хамт Сэлэнгэ мөрний хөндийд ХҮП зууны дунд үед ирж суурьшсантай давхцажээ. Энэ үеэс эхлэн бүддийн шашин буриадуудын бараг бүх бүлэгийн дунд дэлгэрч XIX зууны үед зохион байгуулалтын хувьд сайн бэхжиж чадсан байлаа.

Буриадад ХҮШ зууныг хүртэл бүддийн шашны сүүрин дацан үгүй, лам нар ард иргэдийн хамт нүүж, шашны хурал номыг ноёдын өргөө гэр болон нийтийн томоохон гэрт уншдаг байжээ. Харин тухайн үеийн Монголд томоохон шашны төвүүд байгуулагдаж, өөрийн хутагт, хувилгаадыг тодруулан, сүм хийдийн нарийн зохион байгуулалттай болсон байжээ. Тухайн үед буриад үндэстэн төлөвшөөгүй байсан тул буриадууд шашны үйл хэргээр нийт монголын төвтэй шууд холбоотой байлаа. Монгол болон түвд лам нар буриадын нутгаар явж, номлол айлдахаас гадна тэндээ суурьших нь элбэг тохиолдож байв. 1676-1712 оны хооронд 150 гаруй монгол ба түвд лам нар өмнөд буриадын нутагт ирж суурьшин, буриад лам нарын хамт буриадуудын дунд бүддийн шашныг дэлгэрүүлэх үйл хэргийг эхлүүлсэн ажээ.

Буриадуудын дунд бүддийн шашны дэлгэрэлт нь аажмаар хийгээд жигд бус явагдаж байлаа. Зүүн буриадуудын дунд бүддийн шашин илүү өргөн дэлгэрсэн бол баруун буриадуудын дийлэнх нь бөө мөргөлтэй хэвээр үлдэж, тэдний цөөн хэсэг нь христийн шашинд орсон байна.

Буриадуудын дунд бүддийн шашны дэлгэрэлтийн эхэн үед Дондов лам, Жамъян Сунрав, Лувсан-Шарав, Ёндон гэлэн зэрэг монгол лам нар хийгээд Чойж Агваан-Пунцаг хэмээх түвд лам чухал үүрэг гүйцэтгэжээ.

## II. Бүддийн шашны анхны дацангууд

---

<sup>1</sup> Исследование выполнено при финансовой поддержке РГНФ в рамках проекта проведения научных исследований № 14-01-00344 (Реалии монашеской дисциплины в буддизме).

•Буриадын анхны дацан сэлэнгэ ба хори буриядуудын дунд байгуулагдав. Тухайлбал, буриадын анхны гэр хийд болох сартуулын буюу Бургалтайн хийдийг 1707 онд байгуулжээ.

•1712 – 150 түвд ба монгол лам нар ирж байгаа нь.

•1730 – Балдан Брэйбэн бую сонгоолын дацан Сухээ голын хөвөөнд Хялгант хэмээх газарт барьжээ.

•1741 – Галуут нуурын дацан баригдсан

•1741 – бүддийн шашны дацан ба лам нарын тооны тухай анхны албан ёсны мэдээ (11 дацан, 150 лам). Елизавета хатан хааны зарлиг.

•1753 онд Д.-Д.Заяевыг бандида хамба ламаар томилсноос хойш дацангийн хамбаар буриад лам нарыг тавих болжээ.

•1758 - Тугнугалтайн дацангийн барилгын ажил – хори буриядуудын дунд бүддийн шашин дэлгэрч эхэлсэн нь.

•1801 – Агын буриядуудын дунд бүддийн шашин дэлгэрч эхэлсэн нь. Чулуу буюу модоор барьсан анхны суурин хийдийг зүүн Буриадад 1801-1802 онд байгуулжээ.

Бүддийн шашны Анхны дацангуудын барилга архитектурын онцлог нь орос, түвд, хятад уламжлалыг дагасанд оршино. Эхэндээ дацангийн суурь нь орос модон байшин ба сүмийн загвар болж байв.

XIX зууны эхинд буриад дацангуудад өөрийн гэсэн барилгын хэв маяг хийгээд уламжлал тогтож, энэ цагаас хойш дацангуудыг монгол-түвдийн уламжлалт загвараар барих болжээ.

Бүддийн шашны дэлгэрэлтийг хяналтандаа авах зорилгоор эзэнт гүрний төрөөс лам нар болон дацангуудыг бүртгэлд хамаруулжээ. I Екатерина хатан хааны 1741 онд гаргасан зарлигаар / бүддийн шашныг Орос гүрний албан ёсны нэг шашин болгож, лам нарын орон тоог 150 хязгаарлажээ. Гагцхүү Үнэн алдартны шашныг төрийн шашин хэвээр үлдээжээ. 1741 оны энэхүү зарлиг нь буриадын бүддийн шашныг бие даан хөгжих эхлэлийг тавьж өгсөн юм.

Хаант засгийн газраас явуулж байсан хавчих бодлогыг эс харгалзан буриядууд бүддийн шашны ертөнц болон монголчуудтай харилцаатай хэвээр байлаа.

Буриадын бүддийн шашны сүм, хийд нь мэдлэг боловсролын төв болж, сүсэгтэн олны хүүхэд залуучуудыг бичиг үсэгт суралцуулах болов. Хийдэд номын хэвлэл, номын гар зургийн урлаг төвлөрч байсан.

Буриадын бүддийн шашинтан баян уу, ядуу юу, сүсэгтэй юу, сүсэггүй юу сүм хийдтэйгээ мянган шижмээр холбоотой болсон юм.

XIX зууны дунд үеэс Агын дацан гүн ухаан, зурхайн ухаан, тарнийн ёс, анагаах ухааны факультеттай хамгийн том хийдийн их сургууль болон хувирчээ. Лам нарын нийт тоо 1 мянгад хүрч байв.

XX зуун гарахад Агын дацан 20 гаруй үндсэн хийгээд туслах чанарын барилга байгууламжтай томоохон сүүрин газар болсон байлаа.

Европод (Санкт-Петербург хотод) барьсан бүддийн шашны анхны хийдийг Түвд ба Монголын бүддийн шашны нэрт зүтгэлтэн буриад лам Агван Доржиевийн санаачилгаар XIII Далай ламын өгсөн хандив, Агван Доржиев ламын хувийн хөрөнгө болон 1909-1915 оны хооронд түүний санаачилгаар Орос ба Монголын буриад болон халимагуудаас цуглуулсан хандивийн хөрөнгөөр байгуулсан юм.

XIX зууны сүүл XX зууны эхэн үеийг буриадын соёлд бүддийн шашны гүн ухаан болон боловсролын үзүүлсэн оюун санааны нөлөө үлэмж байсан тул энэ үеийг **буриадын гэгээрлийн үе** хэмээн зүй ёсоор нэрлэж байна. Энэ хугацаанд лам нар хийгээд дацангийн тоо үлэмж нэмэгджээ. ТОБОЕВ Ганжурва Иролтуев, Итигилов.

20-30-аад онд орон даяар бараг бүх сүм дуганыг устгахад эдгээр барилга байгууламжаас зөвхөн 4 нь бүтэн үлджээ. 1946 онд ганц хийдийг нээхийг зөвшөөрсөн.

#### ДАЦАНГИЙН ТООНЫ ӨСӨЛТИЙГ ДАРААХ ХҮСНЭГТЭЭС ХАРНА ҮҮ:

- 1886 – 34 хийдийн цогцолбор
- 1916 – 44
- 1920-иод оны сүүл-1930-аад он – хэлмэгдлийн үе.
- 1940 он гарахад бүх сүм дуганыг устгасан байлаа. Бүддийн шашны сүм хийд нийгмийн институтийн хувьд үгүй болсон байв.

#### ЛАМ НАРЫН ТОО БОЛОН ТЭДНИЙ ТООНЫ ӨСӨЛТИЙГ ДАРААХ ХҮСНЭГТЭЭС ХАРНА УУ:

- 1741 – 150 лам нар
- 1774 – 617
- 1822 – 2502
- 1831 – 4637
- 1916 – 11276 лам нар. Энэ бол 1917 оны хувьсгалаас өмнө байсан лам нарын тооны хамгийн өндөр үзүүлэлт юм. Лам нарын тоо хэрхэн өсч байсан хийгээд цаашид шашингүй үзлийг дэлгэрүүлэх болсноор лам нарын тоо хэрхэн буурсан нь харагдаж байна.

- 1927 – 7566
- 1930 – 5327
- 1933 – 2758
- 1934 – 1515
- 1935 – 1271
- 1936 – 923
- 1938 (11 сарын 1-ий байдлаар) – 1864 лам нар баривчлагдсан
- 1948 – 565 (477 лам нар янз бүрийн туслах чанарын ажил эрхэлж, 88 нь – байнгын оршин суугаа хаяггүй байжээ)

XX зууны 30-40-өөд он – Энэ үед шашны байгууллага болон / лам нарыг хэлмэгдүүлэн, хороож устгав.

1944-2009 оны үе. Энэ үеийг дотор нь хоёр үеер хувааж болох юм. Үүнд:

1944 – 1980-аад оны сүүл

- 1944 – 1945 – хэлмэгдүүлэх бодлого өөрчлөгдөн төр шашны харилцаа аажмаар хэвийн болж байгаа нь.

- 1945 – Шинээр Иволгийн дацан барих ба Агын дацангийн үйл ажиллагааг 20 ламтай сэргээх албан ёсны зөвшөөрөл

- 1946 – 1970-аад оны дунд үе – шашингүй үзлийн суртал ухуулага идэвхжсэн үе.

- 1956 оноос эхлэн лам нарыг цагаатгаж эхэлсэн нь.

- 1970-аад оны дунд үе – 1980-аад оны сүүл – бодлогын өөрчлөлт – хэсэг зуур эрх чөлөөтэй болсон үе: Монголд бүддийн шашны дээд сургууль нээгдэж, олон улсын харилцаа дэлгэрсэн үе.

- Засаг төрийн зүгээс бүрэн хяналт тогтоосон үе.

1970 онд Монголд Гандантэгчинлин хийдийн дэргэд бүддийн шашны дээд сургууль нээхийг зөвшөөрсөн тул Буриадаас 10 хуврагийг суралцахаар илгээжээ. Тус дээд сургууль байгуулагдснаар / бүддийн шашны ирээдүйн сэргэн мандалтын үйл явцын эхлэл тавигдсан юм.

1. XX зууны 80-аад оны сүүлээс бүх шашин түүний дотор бүддийн шашны сэргэн мандалтын шинэ эрин үе эхэлжээ. 1990, 1997 онуудад оросын “шашин шүтлэгийн эрх чөлөөний тухай хууль” гарснаар төр шашны хоорондын эрх зүйн харилцааг тогтоож өгчээ. Уг хуулиар шашны байгууллагыг биеэ даасан эрх зүйн субъект болгож өгснөөр шашны байгууллагууд хараат бус бүрэн биеэ даах болжээ. Шашны байгууллагуудыг биеэ даасан эрх зүйн субъект мөн гэж хууль ёсоор хүлээн зөвшөөрсөн нь.

Өнгөрсөн зууны 80-аад оноос хойш бүддийн шашин аажмаар сэргэж, шашны сүм дуганыг сэргээн барих болжээ.

Буриадын бүддийн шашны хийд нь хийдийн уламжлалт үйл ажиллагаа, хийдийн боловсролын тогтолцоо, бүддийн гүн ухаан, логик, калачакра, бүддийн дүрслэх урлаг буюу чойрыг сэргээхэд бусад шашны нэгэн адил тусламж авчээ. Буриадын дацанд боловсрол олсон лам нар Монгол болон Энэтхэгийн бүддийн шашны хийдэд шавилан сууж, шашны боловсролоо гүнзгийрүүлж байна.

Эдүгээ Буриадад 1000 лам хувраг байна. Хууль Зүйн Яамны 2009 оны мэдээгээр Буриадад албан ёсоор 54 бүддийн шашны нийгэмлэг байна.

Шашны алдагдсан уламжлал хийгээд хурал номын бүрэн бүтэн байдлыг сэргээх үйл явц амжилттай явагдаж байна. Хэрэв эхэн үедээ хурлыг явуулах болон зан үйлийг сэргээхдээ төвд лам багш нарын тусламж авдаг байсан бол одоо буриад лам нар энэ бүхнийг бие даан явуулж байна.

Шашны зан үйлийг бүрэн хэмжээгээр сэргээхийн хамт шинэлэг зүй гарчээ: шашны боловсролыг иргэний боловсролтой (дээд эсвэл дунд) хослуулж байна. жишээлбэл Лам нар бүддийн шашны анагаах ухааны дээд сургууль дүүргээд анагаах ухааны дунд мэргэжилтний диплом болон уламжлалт анагаах ухааны их эмчийн диплом авч болох ажээ.

Шашны амьдралд гарсан шинэлэг үзэгдэл бол буриадын бүддийн шашны түүхэнд анх удаа эмэгтэйчүүдийн бүддийн шашны хийд болон “Ногоон дарь эх” хэмээх эмэгтэйчүүдийн иргэний бүддийн шашны нийгэмлэг байгуулагджээ.

Байгалийн чанад дахь орчин үеийн шашны байдлын онцлог шинж чанар нь бүддийн шашныг сэргээхийн хамт бөө мөргөл сэргэж байна, шашны хүлээцтэй байдал тогтсонд оршино.

Шашны нийгэмлэгүүдэд гарч буй эдгээр өөрчлөлтүүд нь Байгалийн чанад дахь шашны нөхцөл байдлыг тооны болон чанарын хувьд өөрчилсөн байна. Үүний хамт бүддийн шашин нь буриадуудын уламжлалт үндсэн шашин хэвээр байгаа юм.

Эдүгээ бүддийн шашны нэр хүнд өсч, орчин үеийн бүс нутгийн соёлын хөгжилд түүний үзүүлж буй нөлөө нэмэгдэж, бүддийн сүм хийдүүд нийгмийн амьдралд идэвхитэй оролцох болжээ.

1980-аад оны сүүлээс – бүддийн шашны сэргэн мандандалтын үе

- Хуучин дацанг сэргээж шинээр нэмж барьсан нь (54 бүддийн шашны нийгэмлэг).
- Эдүгээ 1000 орчим лам хуврагууд байна.
- Хийдийн боловсролын тогтолцоо болон шашны зан үйлийн шинэтгэл ба сэргэн мандалт

- Шинэлэг зүйл: шашны боловсролыг иргэний боловсролтой холбож байгаа нь
- Буриадад уламжлал болоогүй бүддийн шашны сургууль дэлгэрэх болсон нь
- Шинэ хандлага: сүм хийдийн хөрөнгийг хурааж хар төрийн нийгэмлэг байгуулах ба эмэгтэйчүүдийн хөдөлгөөн – Байгалийн чанадад эмэгтэйчүүдийн бүддийн шашны хөдөлгөөн шинэлэг зүйл болов. “Ногоон дарь эх” хэмээх иргэний эмэгтэйчүүдийн нийгэмлэг байгуулагдав. Анхны бүддийн шашны эмэгтэйчүүдийн хийд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус хийд Монголын хандмаа нартай нягт холбоотой ажилладаг.

- Бүддийн шашны хийд болон нийгэмлэгүүд нийгмийн амьдралд идэвхитэй оролцож байгаа нь.

- Бүддийн шашны нэр хүнд өсч тус бүс нутгийн орчин үеийн соёл төлөвшихөд түүний нөлөө үлэмж болж байна.

- Байгалийн чанад дахь орчин үеийн шашны байдлын онцлог шинж чанар нь бүддийн шашныг сэргээхийн хамт бөө мөргөл сэргэж шашны хүлээцтэй байдал тогтсонд оршино.